

**ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ГАЗАР, ХЭЛТЭС,
АГЕНТЛАГУУДАД ЯВЦЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ИЛТГЭХ ХУУДАС**

2023 оны 05 дугаар сарын 24

Мандалговь хот

Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилттэй танилцан, ажил эрчимжүүлэх чиглэлээр мэдээлэл арга зүйгээр ханган, зөвлөн тусалж байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд оршино.

Хугацаа: 2023 оны 05 дугаар сарын 01-ээс 05 дугаар сарын 16 хүртэл

Хамрах хүрээ: Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 20 хэлтэс, агентлагууд /2022 оны үйл ажиллагааны үр дүнгээр Санаачилгатай сайн үнэлэгдсэн 3 агентлагаар орохгүй/

Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагийн үйл ажиллагаатай танилцан зөвлөн туслах арга хэмжээг хариуцсан хэлтсийн мэргэжилтнийг дагуулан зохион байгууллаа. Үүнд:

- 1.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлт /Аймгийн сайтад байршуулсан мэдээллийг шалгуур үзүүлэлт тус бүрээр, фейж хуудас хөгжүүлэлт/
Байгууллагын ил тод, нээлттэй байдлын 46 шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллээ байршуулсан 14 байгууллага, мэдээллээ байршуулаагүй 6 байгууллагад байгууллагын ил тод, нээлттэй байдлын 98 шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллээ байршуулах, мөн холбогдох мэргэжилтнээс зөвлөгөө авч байршуулах, байгууллага тусдаа сайттай болох тараар зөвлөмж өгч ажиллалаа. Байгууллагын фейж хуудасгүй албан байгууллага байхгүй байна.
- 1.2 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцан цаашид хэрхэн ажиллах гарц, богино хугацаанд үр дүнд хүрэх арга замыг ярилцан зөвлөлдөж, хэрэгжилтийг тоо баримттай, ойлгомжтой байдлаар үр дүн талаас нь тайлагнахыг зөвлөсөн.
- 1.3 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн байгууллагад хамааралтай заалтуудын хэрэгжилтийг сар бүр өсөлттэй үр дүнд хүрсэн байхаар ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхийг зөвлөж ажиллалаа.
- 1.4 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тухайн байгууллагад хамааралтай заалтуудыг хэрхэн хэрэгжүүлж байгаатай танилцан сар бүр эрчимжүүлж ажиллахаас гадна жилийн цэсээр бүх агентлагт нийтлэг хамааралтай заалтуудыг нэмж хяналтад авч хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлөө.
- 1.5 Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт
Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн байдал, хэрэгжилтийн явцтай танилцан цаашид хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгч, хамааралтай заалтуудын талаар мэдээлэл өгсөн.

- 1.6 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт /аймгаас тусгайлан оруулах заалтуудыг тусгасан эсэх
Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралт болох байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлтийг байгууллагуудын болон аймгийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулж зорилго зорилт, шалгуур үзүүлэлтээ оновчтой тодорхойлоогүй байсан агентлагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө, мөн нэгжийн болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлтийг сайжруулах арга зүйн зөвлөгөө өгч 5 байгууллага, 10 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дахин хянаж сайжруулах арга хэмжээ авсан. Мөн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгагдсан агентлагийн дарга нарын хүлээх 18-23 үүргийг хэрхэн хэрэгжүүлж, тайлагнах талаар зөвлөмж өгсөн.
- 1.7 Байгууллагын гүйцэтгэлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжийн хэрэгжилт
Агентлагуудын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн 6 зөвлөмжийн хэрэгжилттэй танилцан дутагдалтай байсан арга хэмжээнүүдийг хариуцсан албан хаагч нарт зөвлөгөө зөвлөмж өгсөн.
- 1.8 Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төлөвлөлт
Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт болох төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг журмын дагуу боловсруулаагүй байсныг сайжруулах талаар холбогдох албан хаагчдад арга зүйн зөвлөгөө өгсөн.
- 1.9 Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагуудын 2022-2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг аймгийн Эдийн Засаг нийгмийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөлт, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт болон салбаруудын статистик үзүүлэлттэй уялдуулан шинэчлэн боловсрууллаа.
- 1.10 Аймагас дэвшүүлсэн зорилтын хүрээнд дэх төлөвлөлт
Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилийн хүрээнд тухайн агентлагуудын хийх ажлыг төлөвлөлтийн байдалтай танилцаж төлөвлөгөө гаргаагүй байсан агентлагуудыг төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилт үр дүнг хагас бүтэн жилээр тооцон хүргүүлж байх талаар мэдэгдсэн.
- 1.11 Байгууллагын цахим шилжилт /СӨГ, албан бичиг/
Байгууллагын ERP ашиглалт болон, ӨГСХ-ийн бүртгэл, шийдвэрлэлт, албан бичгийн явсан бичгийн бүртгэл, ирсэн бичгийн бүртгэл шийдвэрлэлтийн байдалтай танилцаж, ирсэн явсан бичиг бүртгэж, шийдвэрлэлт оруулаагүй агентлагуудад бүртгэл хөтлөх шийдвэрлэлт оруулах талаар зөвлөмж өгсөн. ӨГСХ-ийн бүртгэл хөтлөөгүй, цахимжуулаагүй 2 агентлагт мөн бүртгэл хөтлөх ер, системд оруулж шийдвэрлэх талаар зөвлөмж өгсөн.
- 1.12 Агентлагуудын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний загварын дагуу төлөвлөлтөө хийсэн байдалд явцын хяналт хийж төлөвлөлт хангалтгүй байсан агентлагуудад зөвлөмж өгсөн. Өгсөн зөвлөмжийн хүрээнд ил тод байдлын 46 шалгуур үзүүлэлт, хууль тогтоол шийдвэрийг эрчимжүүлэх үүднээс сар бүрийн эхний 10 хоногт хууль тогтоол

шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, мөн байгууллагын цахим албан хэрэг хөтлөлт, ERP системийн ашиглалтыг сайжруулах, төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх гэх мэт зөвлөмжийн хэрэгжилт агентлагуудад удаашралтай байсныг эрчимжүүлэх талаар удирдлагууд болон холбогдох мэргэжилтнүүдэд дахин зөвлөлөө.



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС